

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
“БАГАНУУР ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН
2025 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 09 дүгээр сарын 08

Багануур дүүрэг

Зорилт (бодлогын баримт бичгийн үндэслэл)	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Суурь түвшин 2024-2025	Хүрэх түвшин, үр дүн, төсөв 2025 он				Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Төсөв	Эх үүсвэр	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Үйлдвэрлэл, инноваци										
3.2.Багануур дүүргийг үйлдвэрлэл, инновацийн төв болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.s										
3.2.1.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлнэ. (АХ-2050-2.4, ЗГҮАХ 1.2.1.3, МУХТЖҮЧ-2.4, МУ-ын 2021- 2025 оны ХОХ-74, НЗДҮАХ-3.3.1)	186	Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барина.	БҮТП	Батлагдсан зураг төсөвтэй.	лын явцыг 23% д хүргэсэн байна.	700.0	Нийслэлийн төсөв	-	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг худалдан авах 700.0 сая, засвар хийж ашиглалтад оруулах 2,329.0 сая, нийт 3,029.0 сая төгрөгийн төсөвтэй ажил юм. - Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60% буюу 1,740.0 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 700.0 сая төгрөг тусгагдсан. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилга худалдан авах ажлыг НХОГ-т 2025.02.06- ны 36 дугаар албан бичгээр хүсэлтээ уламжилсан боловч төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдэж	-

									хасагдсан тул уг арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон. - Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Паркийн "захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийн 35.0 сая.төг санхүүжилт шийдвэрлэгдэж. "Нутаг консалтинг" ХХК нь захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийн зураг төслийг гүйцэтгэж 2020 онд хүлээлгэн өгсөн байна. Тухайн барилгыг барихад шаардлагатай 2454.2 сая.төгийг нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэж зураг төслийн төсөв шинэчлэх хүсэлтийг 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар албан бичгээр "Нутаг консалтинг" ХХК-д хүргүүлсэн. Үүний дагуу автор 3.0 сая.төгрөгөөр төсөв шинэчлэхээр санал ирүүлсэн тул холбогдох асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

	187	Паркийн цахилгаан хангамжийн 110/35/10 кв-ын 2*17МВА чадалтай үндсэн дэд станцыг барина.	БҮТП	1. ТЭЗҮ, болон Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон гадна инженерийн батлагдсан зураг төсөлтэй 2. паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 4.3 км урт 110кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил хийгдсэн (бүтээн байгуулалт 90% тай.)	Ажлын явцыг 20% д хүргэсэн байна.	1,048.9	Нийслэлийн төсөв	-	Паркийн цахилгаан хангамжийн 110/35/10 кв-ын 2*17МВА чадалтай үндсэн дэд станцыг барих ажлын хүрээнд: - Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х17мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Гүйцэтгэгчээр Эм Ай Эс Эс ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 гэрээ байгуулсан. - 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдөр “Эм Ай Эс Эс” ХХК-аас дэд станцын бүтээн байгуулалтын ажилтай холбогдуулан газар дээр нь ажилласан. Ажил эхлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлсэн хүлээгдэж байна.	60
	188	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн 110 кв-ын 6.76 км шугамын бүтээн байгуулалтыг дуусгана.	БҮТП	Ажлын явц 80% тай.	110 кВ-ын 6.76 км шугамын бүтээн байгуулалтыг дуусгана.	300.0	Нийслэлийн төсөв	300.0	- Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/197 тоот дугаартай захирамжийн дагуу паркийн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 6.76 км өндөр хүчдэлийн агаарын шугамын бүтээн байгуулалтын үлдэгдэл 2025 онд санхүүжих 300.0 сая.төгийн эрхийг Нийслэлийн	100

									хөрөнгө оруулалтын газарт шилжүүлсэн. - Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110 кВ-ын 2 хэлхээт 6.76 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын 2025 оны А/21 тоот тушаалын дагуу 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр техникийн комисс ажиллаж. - Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн дарга Д.Батзоригор ахлуулсан Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.	
3.3.2 Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжих		Үйлдвэрлэл, технологийн паркад нэгж элсүүлэх	БҮТП	1	2	-	-	-	Паркад нэгж үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллана байна. Үүнд: - “Натур ларикс вүүд” ХХК нь Багануур дүүргийн 3 дугаар хороонд мод бэлтгэлийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үндсэн түүхий эд болон үйлдвэрлэлийн явцаас хаягдах түүхий эд материалаар зиг-заг хавтан, модны үртсэн блок, тавилгын	100

								үйлдвэр зэрэг чиглэлээр цогц кластер үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой. Паркийн хөнгөн үйлдвэрлэлийн бүсэд нэгжээр элсэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил явагдаж байна. - Мөн Багануур “Мах маркет” ХХК нь малын махаар бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд өдөрт 200 бод, 1000 бог төхөөрч, боловсруулах хүчин чадалтай экспортын чиглэлтэй үйлдвэр юм. Үйлдвэрлэлийн явцаас хаягдах дайвар түүхий эдэд тулгуурлан Паркийн хүнсний үйлдвэрлэлийн бүсэд дайвар боловсруулах, яс боловсруулах, малын тэжээл бэлтгэх, муур нохойн хоол үйлдвэрлэх зэрэг экспортын үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэхээр хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан. Кластер үйлдвэрийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажил явагдаж байна. - Паркийн хүнд үйлдвэрлэлийн бүсэд “Трее Треелинг ойл” ХХК нь хүрэн нүүрснээс синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх мөн хагас коксжуулсан нүүрс, байгалийн газ үйлдвэрлэхээр 2025 оны 07 дугаар сарын 09-
--	--	--	--	--	--	--	--	---

									ний өдөр хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан ажиллаж байна. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр төсөлтэй холбогдуулан уулзалт зохион байгуулан зарим асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. - Дээрх 3 үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хянаж баталгаажуулсны дараа Паркийн нэгжийн удирдлагатай байгуулах гэрээ, Паркийн нэгжид газар ашиглуулах гэрээ байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.		
										Хэрэгжилт	86,6

ХЯНАСАН:

“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ



БОЛОВСРУУЛСАН:

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА Б.МӨНГӨНХУЯГ